

MJEED – JR ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ОНЛАЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн Хамтарсан судалгааны хөтөлбөрийн үйл ажиллагаагаар дамжуулан хуримтлуулсан судалгааны төслийн хэрэгжилттэй холбоотой туршлагыг хуваалцах “MJEED-JR ТУРШЛАГА СОЛИЛЦОХ” онлайн хэлэлцүүлгийг 2021 оны 11-р сарын 10-11-ний өдрүүдэд дараах 4 үндсэн чиглэлээр зохион байгуулна. Үүнд:

- Судалгааны төсөл ба менежмент
- Судалгааны төслийн үр өгөөжийг хүртэх нь
- Судалгааны орчин, лабораторийн ашиглалтыг тойрсон асуудлууд
- Япон Улсад зэргийн болон зэргийн бус сургалтаар суралцахуй

Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, туршлага мэдээлэл солилцох, үр өгөөжийг дээшлүүлэх, цар хүрээг өргөжүүлэх зорилгоор онлайн хэлэлцүүлгийг 2021, 2022 онд үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөж байна.

1000 инженер буюу “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд хэрэгжиж буй **Хамтарсан судалгааны хөтөлбөрийн** үйл ажиллагаа 2014 оноос эхэлсэн ба МУИС болон ШУТИС-ийн судалгааны тэргүүлэх 4 чиглэлээр 20 судалгааны баг Японы улсын 60 гаруй их, дээд сургууль болон судалгааны хүрээлэнгүүдтэй эрдэм шинжилгээ, инновацийн судалгааны төслүүдийг хамтран хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд, их сургуулиудын багшлах хүний нөөцийг бэлтгэх, хамтарсан судалгааны ажлын агуулгыг сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор магистр, доктор, зэргийн бус болон зочин профессор хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Мөн, сургалт, судалгааны тоног төхөөрөмжийг сайжруулах, лабораторийг хөгжүүлэх зорилгоор хоёр их сургуульд багаж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг шат дараатайгаар зохион байгуулж байна.

“ИТДБ” төсөл хэрэгжүүлэх нэгж

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР

2021 оны 11-р сарын 10-ны өдөр Лхавга гариг

ӨДӨР 1	Хэлэлцүүлгийн чиглэл, илтгэлийн сэдэв	Илтгэгч/чиглүүлэгч
09:30	Мэндчилгээ	Д.Намсрай
09:40	Хамтарсан судалгааны хөтөлбөрийн танилцуулга	Т.Амаржаргалан
10:00	НЭГ. СУДАЛГААНЫ ТӨСӨЛ БА МЕНЕЖМЕНТ	Ж.БАТХҮҮ
10:00	1.1 Төслийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлсэн туршлагаас	Д.Ганбат, ШУТИС
10:40	1.2 Судалгааны багийн хүний нөөцийг бэлтгэж буй байдал	Г.Хишигжаргал, ШУТИС
11:20	1.3 Судалгааны төслийг ажлыг удирдах нь	О.Алтансүх, МУИС
13:00	ХОЁР. СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖИЙГ ХҮРТЭХ НЬ	Б.СЭРГЭЛЭН А.АМАРБАЯР
13:00	2.1 Судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудлаар	А.Энхбаяр, МУИС
13:40	2.2 Суурь судалгааны ажлын үр өгөөж	Б.Даваапүрэв, МУИС
14:20	2.3 Судалгааны үр дүнг ашиглахтай холбоотой боломж, бэрхшээлүүд	Ч.Ганзориг, МУИС
15:00	ГУРАВ. СУДАЛГААНЫ ОРЧИН, ЛАБОРАТОРИЙН АШИГЛАЛТЫГ ТОЙРСОН АСУУДЛУУД	Ч.ГАНЗОРИГ
15:00	3.1 Японы лабораториос суралцахуй	О.Мөнхцэцэг, ШУТИС
15:40	3.2 Судалгааны тоног төхөөрөмжийн "нийлүүлэлт-суурилуулалт-ашиглалт" дахь шийдвэрлэх асуудлууд	Д.Сүнжидмаа, ШУТИС
16:20	3.3 Нээлтэй лабораториудын үйл ажиллагаа ба ашиглалт	М.Дэлгэрмаа, ШУТИС
17:00	Хаалт	Д.Намсрай